



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/767

Арвайхээр

Нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах тухай


Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалт болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруунбаян-Улаан суманд баригдаж буй 100 хүүхдийн дотуур байрны барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Цагаан бургалтай” ХХК-ийн гүйцэтгэж буй ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй Бетон суурьтай гадна хашаа, гадна гэрэлтүүлэг, гадна гэрэлтүүлгийн хаяг хийх ажлыг нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2. Нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д даалгасугай.

3. Нэмэлт ажилд шаардагдах 30.918.721 (гучин сая есөн зуун арван найм мянга долоон зуун хорин нэг) төгрөгийг Сангийн яаманд уламжлан тендерийн үнийн зөрүү зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101467